



**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР**

# **САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**ДОРНОГОВЬ АЗЗА ТӨХК-ИЙН  
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ**

**Аудитын код: САГ-2018/126/СТА-ТӨҮГ**

**2018 он**

# АГУУЛГА

---

Аудитын гэрчилгээ	
1. Аудитын тайлан.....	1
1.1 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	1
1.2 Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	2
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	2
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	3
1.5 Дотоод хяналт.....	3
1.6 Компанийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар.....	3
1.7 Шилэн дансны мэдээлэл.....	3
1.8 Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	4
1.9 Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар.....	4
1.10 Аудитаар явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	4
1.11 Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	5
1.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
1.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	5
1.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	5
1.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
1.16 Материаллаг байдлын түвшин.....	5
1.17 Санал дүгнэлтийн хэлбэр.....	6
2. Менежментийн захидал.....	7
2.1 Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа, элэгдлийн зардлын талаар.....	8
2.2 Орлогын албан татвараас хасагдахгүй зардлын талаар.....	9
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	11
3.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13





“ДОРНОГОВЬ АЗЗА” ТӨХК-ИЙН  
ЗАХИРАЛ А.БАТТОГТОХ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/747  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\0315SAG78.Docx




071218

## Үүрэг, хариуцлага


“Дорноговь АЗЗА” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



# 1 Аудитын тайлан

## 1.1 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд (САГ-2018/126/СТА-ТӨҮГ) аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, (“НББОУС”), Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн удирдлага санхүүгийн тайлангаа олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-д нийцүүлэн материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 3 дугаар сарын 15-нд байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийн ахлах аудитор Х.Тунгалагмаа, чанарын хяналтын менежер Ц.Цэцэгмаа, аудиторын туслах Д.Дашдулам, З.Доржсүрэн нар хариуцаж ажиллав.

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа “Шинэ их тэрбум аудит” ХХК-д 2018 оны 2 дугаар сарын 19-ний өдөр цахимаар ирүүлсэн.

## 1.2 Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“Дорноговь АЗЗА” ТӨХК нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хувь



хүний орлогын албан татварын тухай, Хөдөлмөрийн тухай, Компанийн тухай, Авто замын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, салбарын яамны баталсан норм норматив, компанийн ТУЗ-ийн тогтоол шийдвэр, бусад заавар журмуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөх дараах хууль болон холбогдох заавар журам, тогтоолуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам
- Авто замын тухай шинэчилсэн хуулийг 2017 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөж эхэлсэн.

### **1.3 Компанийн зорилго, үндсэн үйл ажиллагаа:**

“Дорноговь АЗЗА” ТӨХК хатуу болон хайрган хучилттай зам барих, зам гүүрийн засвар, зам талбайн тохижилт, замын барилга засварын материал, хийцийн үйлдвэрлэл, замын тоноглол тэмдэглэлгээний ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж ирсэн.

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А -1 маягтад тусгасан.

### **1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**

Аудитыг хийдээ СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бусад холбогдох хууль тогтоомж, журам зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитаар “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.  
/ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 6-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/



“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан байгууллагын даргын тушаалаар батлуулан мөрдөж байна. Бодлогын баримт бичгийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу өөрчлөн сайжруулах шаардлагатай болжээ.

“Дорноговь АЗЗА” ТӨХК нь нягтлан бодох бүртгэлийн “Венница” програм ашиглаж байна. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцаж, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” эрсдэлтэй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

### 1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс компанийн материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилгоор дотоод хяналтын төвшинд үнэлгээ хийсэн.

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн уламжлалт болон хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

### 1.6 Компанийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас бүтээгдэхүүн үйлдвэрлэлт буюу борлуулалтын орлогын зорилтот төвшин 1,000.0 сая төгрөгөөр баталсан, гүйцэтгэл нь 1,427.5 сая төгрөг болж давж биелэгдсэн харин ашгийн төлөвлөгөө 12.4 сая төгрөгөөр тасалдсан байна.

“Дорноговь АЗЗА” ТӨХК 2017 онд орон нутгийн чанартай зам засвар, арчлалтын үйл ажиллагаанаас 365.2 сая төгрөг, улсын чанартай зам засвар арчлалтаас 867.3 сая төгрөг, үйл ажиллагааны бусад орлого 194.6 сая төгрөг, бүгд 1,427.1 сая төгрөгийн орлого олж, борлуулалтын өртөг 1,312.1 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 113.1 сая, татварын өмнөх ашиг 7.3 сая төгрөгөөр тооцогдсон байна.

### 1.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлан, таван саяас дээш төгрөгийн гүйлгээг гарсан тухай бүрд нь оруулж, холбогдох мэдээллүүдийг бүрэн байршуулж ирсэн.



## 1.8 Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

## 1.9 Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Санхүүгийн тайлангийн “Хангамжийн материал”-ын 1400402 тоот дансанд бүртгэлтэй 107.5 сая төгрөгийн үнэ бүхий зүйлс нь 2011 онд Монгол Улсад хэрэгжүүлсэн замын төслийн үлдэгдэл хөрөнгөөс шилжиж ирсэн лабораторын тоног төхөөрөмжүүд юм. Эдгээр хөрөнгө нь үндсэн хөрөнгийн шинж чанарыг агуулж байгаа бөгөөд “Дорноговь АЗЗА” ТӨХК-д хэрэгцээ шаардлага багатай хөрөнгө юм.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2015-2016 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг хэлэлцээд, 2017 оны 12 дугаар сард гаргасан 625 дугаар тогтоолд “Ашиглалтгүй байгаа 107.5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг хэрэгцээтэй байгууллагад шилжүүлэх, худалдан борлуулах асуудлыг ...шийдвэрлүүлэх” гэсэн шийдвэр гаргасан байв.

Аудитын явцад шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын борлуулалтын орлогын 66.0 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, нийт зардлын 78.0 хувийг тус тус хамарсан.

## 1.10 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Тухайн аудитаар Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийг зөрчсөн нийт 14.5 сая төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

- Зам засварын зарим тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацааг 5-15 жилээр тогтоож, жилийн элэгдлийн зардлыг 20 хүртэл хувиар тооцож, байгуулсан байна. Эдгээр тоног төхөөрөмжийн элэгдэл байгуулсан хувь хэмжээ нь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулиар тогтоосон хувиас зөрүүтэй байгаас 10.5 сая төгрөгөөр илүү тооцсон байна.
  - Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.
- Гишүүн байгууллагын татвар, шинэ жилийн хүлээн авалт зэрэг 4.0 сая төгрөгийн орлогын албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлуудыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд хасч тооцсон.
  - Зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.





### **1.11 Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Аудитаар залруулагдаагүй алдаагүй болно.

### **1.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

### **1.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

Дараагийн аудитаар дахин шалгах асуудал гараагүй.

### **1.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 14.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, зөвлөмж өглөө.

### **1.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд “Сайн аудит” ХХК аудит хийсэн бөгөөд 3.1 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хангамжийн материалаас үндсэн хөрөнгөнд ангилан бүртгэх нэг зөвлөмж өгснөөс аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг тооцсон байна.

### **1.16 Материаллаг байдлын түвшин**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг сонгон авсан шалтгаан нь “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзлээ.

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,425.3 сая төгрөг бөгөөд 1 хувиар буюу 14.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцов.

### **1.17 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

#### **Зөрчилгүй санал дүгнэлт**

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай



хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 5 хуудас, санхүүгийн тайлангийн тодруулга 7 хуудсыг тус тус хавсаргав.

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

“ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ:



Ц.МИШИГДОРЖ

“ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ” ХХК-ИЙН  
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР:

*C. Цэцэгмаа*

Ц.ЦЭЦЭГМАА

БЭЛТГЭСЭН:

“ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ” ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР:

*X. Тунгалагмаа*

Х.ТУНГАЛАГМАА

2018 оны 3 дугаар сарын 15.

## 2. Менежментийн захидал

---

“Шинэ их тэрбум аудит” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.**

**2.1 Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа, элэгдлийн зардлын Тэргүүлэх ач холбогдол №1 талаар**

**Шинэ их тэрбум аудит ХХК-ийн ажиглалт**

Зам засварын зарим тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацааг 5-15 жилээр тогтоож, жилийн элэгдлийн зардлыг 20 хүртэл хувиар тооцож, байгуулсан байна. Эдгээр тоног төхөөрөмжийн элэгдэл байгуулсан хувь хэмжээ нь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулиар тогтоосон хувиас зөрүүтэй байснаас 10.5 сая төгрөгөөр илүү тооцсон байна.

**Эрсдэлүүд**

Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-д элэгдлийн зардлыг санхүүгийн тайлангийн болон татварын зорилгоор зэрэгцүүлсэн тооцож харуулаагүйгээс орлогын албан татварыг дутуу төлөх, нөхөн татвар, торгууль алданги төлөх эрсдэлтэй болсон.

**Шинэ их тэрбум аудит ХХК-ийн зөвлөмж**

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг Санхүүгийн тайлангийн зорилгоор болон татварын зорилгоор зэрэгцүүлэн тооцож, “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”-ын 13.2-т заасны дагуу энэ зөрүүг орлогын албан татварын тооцоонд оруулан зохицуулж байх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж батлагаажуулав.



**Шинэ их тэрбум аудит ХХК-ийн ажиглалт**

Гишүүн байгууллагын татвар, шинэ жилийн хүлээн авалт зэрэг 4.0 сая төгрөгийн зардлыг орлогын албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлуудыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд хасч тооцсон.

**Эрсдэлүүд**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг дутуу тооцоноос нөхөн татвар, торгууль алданги төлөх эрсдэлтэй.

**Шинэ их тэрбум аудит ХХК-ийн зөвлөмж**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу орлогын албан татварыг тооцоолж байх;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж батлагаажуулав.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

“ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ:

“ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ” ХХК-ИЙН  
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

“ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ” ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР:



Ц.МИШИГДОРЖ

Ц.ЦЭЦЭГМАА

Х.ТУНГАЛАГМАА

2018 оны 3 дугаар сарын 15.




### 3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

“ДОРНОГОВЬ АЗЗА” ТӨХК

#### 3.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(төгрөг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	220,915,517	305,927,548 ✓
1.1.2	Дансны авлага	36,206,943	33,044,932 ✓
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	14,031,612	
1.1.6	Бараа материал	218,711,274	217,974,306 ✓
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	129,090,664	34,646,313 ✓
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>618,956,010</b>	<b>591,593,099</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	768,780,839	703,553,816 ✓
1.2.2	Биет бус хөрөнгө	625,757	54,167 ✓
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>769,406,596</b>	<b>703,607,983</b> ✓
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,388,362,606</b>	<b>1,295,201,082</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	180,093,576	48,900,000 ✓
2.1.1.3	Татварын өр	1,103,475	37,102,133 ✓
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,336,097	
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>184,533,148</b>	<b>86,002,133</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	295,518,696	295,518,696 ✓
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>295,518,696</b>	<b>295,518,696</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>480,051,844</b>	<b>381,520,829</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	1,259,316,594	1,259,316,594 ✓
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	31,497,846	31,497,846 ✓
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	83,989,232	83,989,232 ✓
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	28,114,800	28,114,800 ✓
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(494,607,710)	(489,238,220) ✓
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>908,310,763</b>	<b>913,680,253</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,388,362,607</b>	<b>1,295,201,082</b>



**“ДОРНОГОВЬ АЗЗА” ТӨХК**  
**3.2 АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**  
**2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил**

(Төгрөг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	1,396,934,884	1,427,174,773
2	Борлуулалтын өртөг	1,280,668,081	1,312,114,745
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>116,266,803</b>	<b>115,060,028</b>
5	Хүүний орлого	1,819,853	1,431,057
10	Ерөнхий ба удирдлагын зардал	102,444,697	113,137,625
12	Бусад зардал	6,134,330	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		3,936,539
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>9,507,629</b>	<b>7,290,000</b>
19	Орлогын татварын зардал	1,564,196	729,000
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>7,943,433</b>	<b>6,561,000</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>7,943,433</b>	<b>6,561,000</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>7,943,433</b>	<b>6,561,000</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**“ДОРНОГОВЬ АЗЗА” ТӨХК**  
**3.3 АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил**

[Төгрөг]

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж телегдсэн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,259,316,594</b>	<b>31,497,846</b>	<b>83,989,232</b>	<b>40,500,000</b>	<b>(502,551,142)</b>	<b>912,752,530</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,259,316,594</b>	<b>31,497,846</b>	<b>83,989,232</b>	<b>40,500,000</b>	<b>(502,551,142)</b>	<b>912,752,530</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)					7,943,433	7,943,433
6	Өмчид гарсан өөрчлөлт				(12,385,200)		(12,385,200)
9	<b>2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,259,316,594</b>	<b>31,497,846</b>	<b>83,989,232</b>	<b>28,114,800</b>	<b>(494,607,709)</b>	<b>908,310,763</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(1,191,510)	(1,191,510)
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,259,316,594</b>	<b>31,497,846</b>	<b>83,989,232</b>	<b>28,114,800</b>	<b>(493,416,199)</b>	<b>907,119,253</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					6,561,000	6,561,000
17	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,259,316,594</b>	<b>31,497,846</b>	<b>83,989,232</b>	<b>28,114,800</b>	<b>(489,238,220)</b>	<b>913,680,253</b>





**“ДОРНОГОВЬ АЗЗА” ТӨХК**  
**3.4 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил**

**(Төгрөгөөр)**

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>1,762,889,264</b>	<b>1,471,606,672</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,699,827,146	1,458,198,923
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	263,451	2,959,105
	Бусад мөнгөн орлого	62,798,668	10,448,644
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,578,481,955</b>	<b>1,386,594,641</b>
	Ажиллагчдад төлсөн	237,761,486	269,236,335
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	85,084,100	105,957,839
	Бараа материал худалданаваход төлсөн	780,448,065	800,605,144
	Ашиглалтын зардалд төлсөн	6,048,891	6,573,259
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	269,220,824	138,042,087
	Татварын байгууллагад төлсөн	189,267,494	66,179,976
	Бусад мөнгөн зарлага	10,651,095	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>184,407,309</b>	<b>85,012,031</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>184,407,309</b>	<b>85,012,031</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>36,508,207</b>	<b>220,915,517</b>
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>220,915,517</b>	<b>305,927,548</b>

САГ-2018/126/СТА-ТӨҮГ

